

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд:

“ХҮИ.8. Нүүрс тээвэрлэлтэд гарч байгаа хүндрэлтэй асуудлын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

8.1. Өмнөговь аймгийн Гашуунсухайт-Ганц модны хилийн боомтыг орчин үеийн рентген аппаратаар тоноглон тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх чадварыг сайжруулах, хил дээр гарч байгаа зөрчлийг бууруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт нарт даалгав.

8.2. Нүүрсний экспорттой холбоотой асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд гарч байгаа саатлыг арилгах талаар Хятадын талтай хэлэлцэн шийдвэрлэхийг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР